

“Бэрх Уул” ХК-ийн 2014 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын протокол

2014.04.21

Улаанбаатар хот

“Бэрх Уул” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2014 оны 04 сарын 21-ны өдрийн 10 цаг 10 минутанд “БиДиСек” ХК-ийн хурлын өрөөнд эхлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга Болд овогтой Мэндсайхан, хурал зохион байгуулах комиссын гишүүд Б.Пүрэвбаатар, Ж.Энхцэцэг, Тооллогын комиссын дарга Ж.Энхцэцэг, гишүүдээр Б.Мянганбаяр, Б.Золзаяа, З.Мягмарсүрэн нар оролцов.

Хуралд хувьцаа эзэмшигч Ц.Самданпунцаг, Г.Мөнх-Эрдэнэ, “Тэнгэр капитал” ХХК-ийг төлөөлж Д.Баатаржав, “БиДиСек” ХК-ийг төлөөлж Ө.Даваасүрэн нар оролцож, бусад хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар оролцов.

Тооллогын комиссын гишүүн Б.Мянганбаяр: Бэрх Уул ХК-ийн 2014 оны 04 сарын 21-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг та бүхэнд танилцуулья. Нийт 19,062,080 хувьцаанаас нийтдээ 99,66% буюу 18,996,981 ширхэг хувьцаа эзэмшиж буй 13 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хурлын ирц бүрдэж байгааг та бүхэнд мэдэгдэж байна.

Хурлын дарга Б.Мэндсайхан хурлыг дэгийн танилцуулав.

Хурлын дарга Б.Мэндсайхан: Тайлантай уншиж байх хооронд Бэрх Уул ХК-ийн 2013 онд хийсэн үйл ажиллагааны тайланг товч танилцуулья. Чандганы уурхай дээр нүүрс борлуулах үйл ажиллагаа хийж 18000 тонн нүүрс борлуулсан. Урд жилүүдээс борлуулалтын хэмжээ багассан. Багасах шалтгаан нь нийт нутгаар дулаан байсантай холбоотой нөгөөтэйгүүр манайхаас харьцангуй ойр зайд Баян-Отогийн нүүрсний уурхай идэвхтэй ажиллаж, үүнтэй холбогдуулан 7000 тон нүүрсний борлуулалт багассан байгаа.Тохойбулагийн алтны уурхай дээр олборлох ажиллагаа явуулаагүй, балансын нөөц дууссан. 2013 онд 14,1 га-д техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Компанийн үндсэн оффис 1500 м2 талбайтай, Хэнтий аймгийн Бэрх хотод байдаг, 2013 онд их засварын ажил хийж дуусгасан. Сүүлийн 5 жил ашиглалтгүй орхисон байсаныг засварлаж, ашиглаж ажилласан байгаа. Бэрхэд үндсэн ажиллагаа ийм хэмжээнд явагдсан. 2013 онд 5.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан.

ТУЗ-ын 9 гишүүн түрүүчийн хурлаар сонгогдож ТУЗ-ын даргаар Батбаатар, ТУЗ-ийн гишүүн Жэймс Пассин, Б.Мэндсайхан, Д.Даянбилгүүн, Жэймс Флорес, Жимми Вайлд, Д.Нарангоо, Б.Батхуяг, Б.Батмөнх нар сонгогдож бүтэн жилийн хугацаанд ажилласан. Гүйцэтгэх удирдлагаар Б.Мэндсайхан, Санхүү эрхэлсэн захирлаар Жэймс Флорес, үйл ажиллагаа эрхэлсэн захирлаар Жимми Вайлд нар ажилласан байгаа.

Хэлэлцэх 1-р асуудалтай холбогдуулан товч мэдээллийг хүргэлээ. Та бүхэн тараах материалтай танилцаад саналын хуудсаа бөглөнө үү.

Хэлэлцэх асуудал 2. Компанийн аудитын хорооны дүгнэлт. Аудитын компаниар Эрнст энд Янг компанийг ТУЗ тогтоолоор сонгож ажиллуулсан өнгөрсөн жилийн туршид аудит хийсэн байгаа. Эхний 2 улирлыг 8, 9 сард Бэрхэд очиж хийсэн. 3-р улирлыг 10,11-р сард очиж хийсэн. Жилийн эцсийг Бэрхэд ирж боловсруулалтаа хийсэн байгаа. Эрнст энд Янг сүүлийн 3 жилдээ манайд аудит хийж байгаа. Аудитын дүгнэлтийг тараах материалд гаргасан байгаа.

Энэ жилийн аудитад уул уурхайн компани дээр нөхөн сэргээлтийн сан гэж байгуулж ёстой байсан, манай дээр байгуулагдаагүй байсан тул шинээр байгуулж үүнтэй холбоотой алдагдалын хэмжээ өөссөн байгаа.

3-р асуудал. 2014 оны санхүүгийн төлөвлөгөө батлах. 2014 онд ТУЗ-ийн зардлыг 170,0 сая төгрөгөөр, компанийн нийт орлогын зардлыг 3,3 тэрбум төгрөгөөр, орлогыг 532,7 саяар, төлөвлөгөөт алдаглыг 2,8 тэрбум төгрөгөөр ТУЗ-р баталсан байгаа. Тус асуудлыг хэлэлцэн батлах ёстой. Орлого зардлыг зардлын нэгж үнээр гаргасан байгаа.

4-р асуудал. ТУЗ-ийн гишүүдийг сонгох. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг хурлын материалаас уншиж танилцаад саналаа өгнө үү.

6-р асуудал. Ногдол ашгийн талаархи гаргасан ТУЗ-н шийдвэрийг хэлэлцэх. Түрүүчийн ТУЗ-н хурлаар компани 5,2 тэрбум төгрөгний алдагдалтай ажилласан учраас ногдол ашиг тараахгүй гэсэн ТУЗ тогтоол гарсан, энийг хэлэлцэн батлах.

Хэлэлцэх 6 асуудлаар товч танилцуулга тайлбар хийлээ, хурлын материал тараагдсан, асууж тодруулах зүйл байвал тодруулаад саналаа та бүхэн өгнө үү.

Хувьцаа эзэмшигч: Жоншны тухай юм яриагүй байна. Тэрний талаар мэдээлэл өгнө үү.

Бэрх уул компани үндсэн хөрөнгө оруулагчид, өмнөх 60 жилийн түүхэнд голлох үйлдвэр нь жоншны олборлолт үйлдвэр байгаа. Сүүлийн 1,2 жил, үндсэндээ 2008 оноос хойш жоншны олборлох үйл ажиллагааг зогсоосон. Шалтгаан нь жоншны тогтоц нь гар аргаар болон ил уурхайн аргаар ашиглах боломжгүй, далд уурхайн аргаар ашиглах тогтоцтой болсон. 2-рт дэд бүтцээс харьцангуй хол, 280 км зайд алслагдсан, олборлолт хийлээ гэхэд түүхийгээр нь гадаадад гаргаж борлуулахад эдийн засгийн хувьд үр ашиггүй юм. 3-рт Ашигт малтмалын хуульд ордыг бүрэн ашиглах ёстой гэсэн заалт байдаг, гар аргаар буюу шууд борлуулахаар хэмжээнд олборлолт хийвэл ордыг сорчилж ашиглах болоод байгаа. Энэ 3 шалтгаанаар 2008 оноос хойш жоншны үйлдвэрлэлийг зогсоосон. Жоншны лиценз компанийн нэр дээр, хууль ёсны дагуу байгаа, тус лиценз дээр хуулийн хүрээнд хийгдэх бичиг цаасны ажлыг тогтмол хийж байгаа. Хөрөнгө оруулагчид өнөөдрийг хүртэл ийм алдагдалтай хирнээ дахин хөрөнгө оруулалт хийж яваа гол юм бол энэ жоншны орд дээр эргүүлж ашиглах боловсруулах үйлдвэр барих хэтийн төлөвтэй явж байгаа. 2011 онд 1170 метр гүний өрөмдлөгийн ажил хийсэн, энэ өрөмдлөгийн ажлаар Дэлгэрхааны орд дээр Монгол улсад мөрдөгдөж байгаа стнадартаар 2,2 сая тоннын жоншны нөөцийг тогтоосон байгаа. Энэ жил бид 4,2 метр өрөмдлөгө хийх төлөвлөгөөтэй, бичиг цаасаа хөөцөлдөж байгаа. Дэлгэрхааны орд дээр оросууд байх үедээ газрын гадаргаас 150 метр хүртэлх гүнд нь олборлолт хийгээд авсан, үлдсэн 350 метр нөөцийг авах гэж оролдож байгаа. Нөөц эхний өрөмдлөг дээр тогтоогдсон, гэхдээ бид нарийвчилж өрөмдөх ажлыг төлөвлөж байна.

Хувьцаа эзэмшигч: 2014 онд хийгдэх ажил байхгүй юу?

Хурлын дарга Б.Мэндсайхан: 2014 онд дахиж өрөмдлөгө хийнэ гэж хэлсэн, гэрээ хийгдээгүй байна, төсөв санхүүжилт шийдэгдээгүй учраас төлөвлөж оруулаагүй юм.

Хувьцаа эзэмшигч: 2014 онд өрөмдлөгө хийлээ гэхэд 2015, 2016 онд ашиглалтанд орлоо гэхэд шууд ухаж гаргахгүй юм байна. Ухаад тэндээ боловсруулалт хийгээд, төмөр замаас их хол байна гэсэн.

Хурлын дарга Б.Мэндсайхан: Энэ талаар ТУЗ-ийн нарийн бичгийг дарга тодорхой мэдээллийг хүргэнэ.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Пүрэвбаатар: Сүүлд Прима Флюрспа Канадын компанитай РТО хийх тухай мэдээлэл цацагдсан байгаа. Одоохондоо гэрээ хэрэгжээгүй. Гэрээний гол зорилго нь Прима Флюрспа Канадын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компани, энэ компаниар дамжуулаад Бэрх Уул дээр хөрөнгө оруулалт босгох, тус Канадын компанийн хөрөнгө оруулагч нар Бэрх Уул ХК—руу хөрөнгө оруулагч нар болж орж ирэх. Жоншны уурхайгаа ашиглахын тулд цаад тал нь 15 сая доллар хүртэлх санхүүжилт босгох шаардлагатай байгаа. Үүнтэй холбоотой бэлтгэл ажлууд нь сая ярьсан стандартаар нөөцөө батлуулаад, энэ нь сүүлийн 2 жил хийгдээд явсан. Цаашдаа энэ дээр нэмэгдээд далд уурхайн ТЭЗҮ нэлээд өндөр өртөгтэй, далдаар олборлохоос өөр зам байхгүй нь тодорхой. Хуучин байсан уурхайн ам цооногуудыг ашиглаад, өргөжүүлэлт хийж, баяжуулах үйлдвэр байгуулах ажил юм. Энэ бүх ТЭЗҮ бол одоогийн байгаа тооцоогоор бол ойролцоогоор 15 сая хүртэлх доллар хэрэгтэй. Файрбөрд буюу манай гол хөрөнгө оруулагч Приматай нийлээд хөрөнгө оруулалт босгох, одоо байгаа хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орохгүйгээр, МХБ дээр нэмж хувьцаа гаргахгүй, канадын компанитай хөрөнгө нийлүүлээд тэр компани хөрөнгө оруулагч нараа авчрах. Яваандаа бол Бэрх Уул компани Канадын хөрөнгө оруулалттай компани болж байна гэж ойлгогдож болно. Нэмэлт хөрөнгө оруулалт ийм байдлаар орж ирнэ. Мэдээллүүд явж байгаа ажлууд хийгдэж байгаа. Энэ 2014 жилдээ хөрөнгө оруулалтын орчин сайн байж мөнгө босгож чадвал Бэрх Уул компани үйл ажиллагаагаа эхлэхэд бэлэн болсон. Хуучирсан цооног нөхөн сэргээх ажлуудыг бүгдийг дахин шинээр хийнэ. Хугацаа орно, 2014 онд жоншны олборлолт хийнэ гэж хэлэх боломжгүй.

Эхлээд хөрөнгийн асуудлаа шийдвэл 2015, 2016 оноос хийж болно. Бэрх Уул компанийн Дэлгэрхааны нөөц нь Монголдоо хамгийн том нөөцтэй жоншны орд юм. Хүлээлт их өндөртэй байгаа. Одоогийн байдлаар хуучин байсан нөхөн сэргээлтийн ажлууд, орон нутагтаа нүүрсээ өгөөд явж байна. Үйл ажиллагаа бага хэмжээгээр явж байгаа. 40 орчим ажилчидтай, үйл ажиллагааны зардлыг уурхайн түвшинд барихгүй, бага хэмжээгээр, цаашдаа өргөжвөл том болно. Примацийн талаар гадаад дотоодын мэдээллийн сувгуудаар цацаж байгаа.

Хувьцаа эзэмшигч: Жоншийг Хятад руу экспортлодог уу?

Хурлын дарга Б.Мэндсайхан: Монгол улс жоншийг Монгол Росцветмет компаниар гаргаж байсан, одоо бол хувийн олон компани гаргаж байгаа, Япон, Солонгос, АНУ, ОХУ, Хятад, Украин руу гаргаж байгаа. Жижиг компаниуд голдуу Хятад руу гаргаж байгаа. Бэрх уул 2005-2008 онуудад Украин руу экспорт хийж байсан. Украины зах зээл манай жонш нэлээн нэр хүндтэй.

Хувьцаа эзэмшигч: Улсын хэмжээнд жоншны экспортын дүнг аваад үзвэл жоншны дүн буурч байгаа. Хятадын зах зээл дээрх үнийг хянаад байгаа юм шиг. Буцаад зах зээлийн сэргэлтийн үе буюу танай хөрөнгө оруулалт хийгдээд үйлдвэрлэлийн хувь ирээдүйд давхцаж ёстой.

Хурлын дарга Б.Мэндсайхан: 2017, 2018 онд жоншны үнэ өснө, одоо уналтын үе дээрээ явж байгаа.

Хувьцаа эзэмшигч: Нүүрсээ хаанаас борлуулдаг вэ?

Хурлын дарга Б.Мэндсайхан: Чандаганы нүүрсний уурхайгаас олборлож байгаа нүүрсийг зөвхөн Хэнтий аймгийн Өндөрхааны хэрэглэгч нарт борлуулж байгаа. Гадаадад гаргах талаар нэлээн үзсэн боловч энэ нүүрсний орд нь илчлэг багатай хүрэн нүүрсний орд, дундаж илчлэг нь 2800 орчимтой, Багануурын нүүрснээс доогуур илчлэгтэй. Төмөр замаас хол, хөрсний зузаан 12 м, нүүрсний давхаргын зузаан 5 м энэ ордыг дахиад тээвэрлэж худалдах нь үр ашиггүй юм.

Хувьцаа эзэмшигч: Чандганы нүүрсний уурхайд янз бүрийн бензиний үйлдвэр барих төлөвлөгөө байна уу?

Хурлын дарга Б.Мэндсайхан: Манай компани дээр эзэмшиж байгаа лицензийн хэмжээ 43 га, ойролцоогоор 29 сая орчим тонн, энэ дээр газрын болон боловсруулах үйлдвэр барих нь эдийн засгийн хувьд үр ашиггүй. Бэрх Уул 6 лицензтэй. Алтны 3 лиценз, жоншны 2 лиценз, нүүрсний 1, алтны 3 лиценз оросууд олборлоод нөөц дууссан. Тохойбулагт 2 талбай, Батноров 1 талбай. Одоо техникийн нөхөн сэргээлт хийх хэмжээнд явж байгаа.

Хувьцаа эзэмшигч: Удирдлагын зардал өндөр гарсан байсан. Орлогын дэлгэрэнгүй тайлан дээр байгаа. 2,2 тэрбум төгрөгний зардал гарсан байна.

Хурлын дарга Б.Мэндсайхан: Энэ нь үйл ажиллагааны зардал. 2013 онд оффисын засвар хийсэн. Нийт зардал орсон байгаа. Компани борлуулалтын орлого дөнгөж 300,0-400,0 сая орчим төгрөг. Үндсэн үйл ажиллагааны алдагдал 2,8 орчим тэрбум төгрөг. 5 тэрбум болоод өссөн нь Эрнст энд Янг аудит, Экстракт гээд зөвлөх компаниудын зөвлөмжийн дагуу, хуулийн дагуу уул уурхайн нөхөн сэргээлтийн сан байгуулах ёстой юм байна. Энэ сангийн зардлыг сүүлийн 3 жил байгуулаагүй энэ жил байгуулаад тэр нь алдагдал болж харагдаж байгаа.

Хувьцаа эзэмшигч: Өр бий юу?

Хурлын дарга Б.Мэндсайхан: Өр байгаа. Урьд нь татварын алба, нийгмийн даатгал, банкны хугацаа хэтэрсэн зээлтэй, эрчим хүчинд өртэй байсан. Гадны хөрөнгө оруулагчид төрийн болон улсын байгууллагатай холбогдсон хууль ёсны бүх өрийг дараад хөрөнгө оруулагч нараас хөрвөх нөхцөлтэйгээр зээл авсан. Одоо арилжааны банк, татвар нийгмийн даатгалд өр байхгүй. Сарын тайлангийн өмнө хойно гарсан гэдгээр жоохон өглөг авлага үүсэж явдаг.

Хувьцаа эзэмшигч: Одоо гадаадын хөрөнгө оруулалт орж ирэхээр байна вэ?

Хурлын дарга Б.Мэндсайхан: Одоогийн хувьцаа эзэмшигчид америкийн компани, Прима Флюрспа канадын компани байгаа. Эд нартай хэлцэл хийхээр яригдаж байгаа.

Хувьцаа эзэмшигч: Жоншоо Солонгос руу гаргадаг уу?

Хурлын дарга Б.Мэндсайхан: Манай компани Солонгос руу гаргаж байгаагүй, Украин руу гаргаж байсан. Хамгийн ойрын төмөр замын гарц Бор-Өндөр, Багануур.

Хувьцаа эзэмшигчид та бүхэн саналын хуудсуудаа бөглөөд өгнө үү.

Хурлын дарга Б.Мэндсайхан: Хурлын дэгийн дагуу санал хураалтаа явуулья.

Хурлын төгсгөлд тооллогын комиссын гишүүн Б.Мянганбаяр санал хураалтын дүнг танилцуулав:

1.Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

4.Компанийн шинэ ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдээс Б.Батбаатар 11.11%, Жэймс Пассин 11.11%, Б.Мэндсайхан 11.11%, Д.Даянбилгүүн 11.11%, Жимми Вайлд 11.11%, Жэймс Флорес 11.11% - ийн санал авч хараат гишүүдэд сонгогдлоо. Хараат бус гишүүдэд Б.Батмөнх 11.11%, Б.Батхуяг 11.11%, Д.Нарангоо 11.11%-ийн саналтайгаар сонгогдлоо.

5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

Хурал 11:55 өндөрлөв.

Хурлын протокол хянасан
хурлын дарга



Б.МЭНДСАЙХАН

Хурлын протокол хөтөлсөн

Ж. ЭНХЦЭЦЭГ